



ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2026 оны 02 сарын 06 өдөр

Дугаар А/26

Улаанбаатар хот

ЭХЭМҮТ-ийн 2026 оны мэдээллийн маягт, бичиг хэрэг,
шатахуун худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулах тухай

Байгууллагын санхүүгийн удирдлагын үр дүнг сайжруулж, ил тод байдлыг хангах, эмнэлгийн тусламж үйлчилгээг чанартай түргэн шуурхай үзүүлэх нөхцлийг бүрдүүлэх, өмнөх жилүүдэд буй болсон чадавх ба нөхцлийг улам дээшлүүлэх зорилгоор Монгол улсын төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.4, 16.5.5, "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалт, 45, 46, 47 дугаар зүйл заалтууд, Монгол улсын Засгийн газрын 2024 оны 02 дугаар тоот тогтоолыг тус тус үндэслэн **ТУШААХ нь:**

1. Төвийн 2026 оны маягт, бичиг хэрэг, шатахуун худалдан авах нээлттэй тендерийг зохион байгуулах үнэлгээний хороог дор дурьдсан гишүүдийн бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Э.Өлзийжаргал /ХАБЭА хариуцсан ажилтан/

Нарийн бичгийн дарга: Б.Бадамгарав /ЭТТА-ны инженер/

Гишүүд:
Л.Батзул /ЭМЗТ-ийн эрхлэгч/
Ц.Дарханбат /Тактижент ТББ/
Т.Мөнхзаяа /Олон нийтийн хөгжилд их үйлс,
зөвлөгөө өгөх төв ТББ/

2. Худалдан авалтыг зохион байгуулах ажлын бэлтгэлийг сайтар хангах, хэрэгцээ шаардлагыг нарийвчлан тооцоолох, техникийн тодорхойлолтыг боловсруулахдаа төвийн тасаг нэгжүүд, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд болон төвийн асуудал эрхэлсэн дэд захирлуудын санал хүсэлт, зөвлөмжийг тусгах, тендерийн үйл ажиллагааг зохион байгуулах бүхий л үе шатыг хуульд нийцүүлэн зохион байгуулах, сонгон шалгаруулах үйл ажиллагаанд ашиг сонирхлын зөрчилгүй мэдэгдлийг бичгээр гарган Эрх бүхий албан тушаалтан /Б.Мөнхшүр/-д гаргаж бүртгүүлэхийг Үнэлгээний хорооны дарга / Э.Өлзийжаргал/-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ажилтан /Б.Болор/-д даалгасугай.

ЗАХИРАЛ



Ж.ОТГОНБААТАР

1606060228